

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох  
журмын 2 дугаар хавсралт

**БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ  
ТУХАЙ ГЭРЭЭ /№8/**

"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4, 3 дугаар зүйлийн 3.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу нэг талаас Сэлэнгэ аймаг (хот)-ийн Баянгол сум, (дүүрэг)-ын Засаг дарга С. Ариунбат (цаашид "Засаг дарга" гэх), иногоо талаас "Нүүжигт Баянгол" нахорлод, хоршоо, бүртгэгдээгүй иехордел (цаашид "Бичил уурхай эрхлэгч этгээд" гэх)-ийг төлөөлж захирал (албан тушаал) Ц. Болормаа нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах иехолдоор харилцан тохиролцож 2018 оны 08 дугаар сарын 22-ны одор энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) Баянгол сум (дүүрэг)-д байгуулав.

**ИЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1 Бичил уурхай эрхлэгч этгээд нь Баянгол сум (дүүрэг)-ийн Баян багийн нутаг дэвсгэрт орших Нэрэгжий хөндий нэртэй газрын 4,93 гектар талбай буюу дараах солбицдолд

| Д/д       | Үртраг |     |       | Оргерег |     |       |
|-----------|--------|-----|-------|---------|-----|-------|
|           | Град   | Мин | Сек   | Град    | Мин | Сек   |
| 1         | 106    | 10  | 19.3  | 48      | 43  | 26.62 |
| 2         | 106    | 10  | 21    | 48      | 43  | 26.53 |
| 3         | 106    | 10  | 21.18 | 48      | 43  | 26.54 |
| 4         | 106    | 10  | 21.18 | 48      | 43  | 21.21 |
| 5         | 106    | 10  | 21.18 | 48      | 43  | 22.6  |
| 6         | 106    | 10  | 10.2  | 48      | 43  | 22.6  |
| 7         | 106    | 10  | 10.2  | 48      | 43  | 38.8  |
| 8         | 106    | 10  | 16.37 | 48      | 43  | 38.69 |
| 9         | 106    | 10  | 16.11 | 48      | 43  | 38.61 |
| 10        | 106    | 10  | 14.71 | 48      | 43  | 37.96 |
| 11        | 106    | 10  | 13.5  | 48      | 43  | 37.16 |
| 12        | 106    | 10  | 12.52 | 48      | 43  | 36.24 |
| 13        | 106    | 10  | 11.8  | 48      | 43  | 35.21 |
| 14        | 106    | 10  | 11.36 | 48      | 43  | 34.12 |
| 15        | 106    | 10  | 11.21 | 48      | 43  | 33    |
| 16        | 106    | 10  | 11.36 | 48      | 43  | 31.88 |
| 17        | 106    | 10  | 11.8  | 48      | 43  | 30.79 |
| 18        | 106    | 10  | 12.52 | 48      | 43  | 29.76 |
| 19        | 106    | 10  | 13.5  | 48      | 43  | 28.84 |
| 20        | 106    | 10  | 14.71 | 48      | 43  | 28.04 |
| 21        | 106    | 10  | 16.11 | 48      | 43  | 27.39 |
| 22        | 106    | 10  | 17.65 | 48      | 43  | 26.92 |
| Талбай га |        |     |       | 4.93    |     |       |

энэхүү журмын 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу үүсмэл алт (ashiгт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

## **ХОЁР. СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1. Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын б дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хөрөгжүүлнэ:
- 2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршилын зургийг гэрээнд хавсаргах;
  - 2.1.2. хог хаягдалийн цэгийн байршилыг тогтоох;
  - 2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборласон ашигт малтмалыг ангилан ялах, баяжуулах талбайг тогтоох;
  - 2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдгэй тохиролцсоны үндээн дээр зохих хоронгийг төвлөрүүлэх;
  - 2.1.5. бичил уурхайн ажилтиуудад (цаашид "ажилтан" гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусlamжтайгаар зохион байгуулах;
  - 2.1.6. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;
  - 2.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн толовлогоөний гүйцэтгэлд хяналт тавих;
  - 2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг иолөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсох.

## **ГУРАВ. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хөрөгжүүлнэ:

- 3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;
- 3.1.2. ажилтиуудыг тогтоосон талбайд суурьшуулах;
- 3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдалийн цэгийг байгуулах;
- 3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдэгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;
- 3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;
- 3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мордох, болзошигүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтиуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;
- 3.1.8. ашигт малтмалыг ангилан ялах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;
- 3.1.9. үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгэсний хэрэгсэл ашиглахгүй байх;
- 3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см<sup>3</sup> хүргэлх багтаамжтай дотоод шаталжат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

- 3.1.11. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардала шаардагдах; / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;
- 3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;
- 3.1.13. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сүм, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх;
- 3.1.14. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах;
- 3.1.15. ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх;
- 3.1.16. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээнгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

#### **ДОРӨВ. ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

- 4.1 Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуураан хамтарч ажилана.
- 4.2 Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй. Сүм, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардана.
- 4.3 Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүнж, аймаг (нийслэл)-ийн Засаг даргад дараа оны 1 дутгэр сард багтаан тайлагнана.

#### **ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 5.1 Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцо замаар шийдвэрлэнэ.
- 5.2 Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

#### **ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

- 6.1. Энэхүү гэрээ нь 2018 оны 08 дугаар сарын 22-ны одроос эхэн 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүргэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.
- 6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

#### **ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 7.1 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 7.2 Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх багод сэргээний салигийн хэсэг болно.

|  |                  |
|--|------------------|
| Бархт                                    | Файзар (хот)-    |
| ийн                                      | Баянгол          |
| Засаг дарга                              | Сум (дүүргэг)-ын |
| <i>С. Ариунбаяр</i>                      |                  |
| шэг/эх-/ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, |                  |

ТЭМДЭГ/

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

|  |                      |
|--|----------------------|
| Ж. Чиритүүлийн Сагийн                    | Б. Сагийн            |
| ж.чиритүүлийн сагийн                     | ж.чиритүүлийн сагийн |
| хоршоо) төлөвийж                         | ж.чиритүүлийн сагийн |
| <i>Бархт</i>                             | <i>Багчилал</i>      |
| /эцэг/эх-/ийн нэрлийн гарын үсэг, тамга, | багчилал             |
| тэмдэг/                                  | багчилал             |